

“НИФФОНД БҮХИЙ МОНГОЛЧУУДЫН ХУРАЛ” ЭРХЭЛСНИЙ ДАРМАЛ ХИЙГЭЭД МОНГОЛОО МАНДУУЛАХ ҮЗЭЛТ

Оюун*

* Өвөр Монголын Их Сургуулийн сонин мэдээ, хэвлэлийн ажилтны салбарын эрхлэгч, профессор

Хөрвүүлсэн Л.Норовсүрэн

Түлхүүр үг: хурал, дармал, хэвлэл, тосон дармал, Ниффон, сургаал, уншлага

1905-1906 онд Харчин баруун хошууны жүн ван Гүнсээноров Японд урьд хожид найман сурагчийг томилж суралцуулснаас эхлэн монголчуудын Дорно далайг гаталж Японд суралцах зам тавигджээ. Харь гүрэнд суралцаж байгаа монгол залуус үндэстэн угсаатны мандал буурал, эрх ашиг, соёл гэгээрлийн төлөөнөө бодлогошрон санааширч, улмаар “Ниффонд бүхий монголчуудын хурал” болон эвлэлдэж, хурлын дотроо ерөнхий явдлын бүлэг, эрдэм сургаалын бүлэг гэж гаргаж, хурлын даргыг Өлзий, дэд даргыг урьд хожид Оюундалай, Гаафунга нар хариуцаж байжээ. Энэ хурал нь доройтсон үндэстнээ дуудан сэрээж, сэтгэлийг нэгтгэж бүлгэмдэн тэмцүүлэх, угсаа аймгийн утга соёлыг сайжруулж, олон түмний ухаан мэдлийг нэмэгдүүлэхийн төлөө, Токиод урьд хожид “язгууртан улс” (Зарим хүмүүс “Эх орон” гэж байсан гэж хэлдэг), “Манхын хонх”, “Шинэ монгол” хэмээх сэтгүүлийг нийгмийн эл этгээд жич ивээл дэмжлэгээр эрхлэн гаргажээ.

1. “Язгууртан улс”. Энэ сэтгүүлийг 1930 оны 8-р сард Токиод чулуун бар буюу тосон дармалаар хэвлэл эхлүүлжээ. Тус дармал 16 зүсмийн ерөнхийл-

сөн чанартай сэтгүүл байж, “9-р сарын 18-ны хэрэг хувьсгал”-ын дараа хэвлэл зогсчээ¹. Сэтгүүлийг Асах, Оюундалай хариуцан эрхэлжээ. Энэ бол “Ниффонд бүхий монголчуудын хурал”-ын ууган сэтгүүл болох юм. Улсаас байгуулсан Бейпин дэх Монгол-Төвдийн сургуулийн захирал Яринпилийн мунхаг бядуу, чадалгүй мөртөө сургуулийг дураар шилжүүлж сургуулийн дүрмийг хувируулснаас болж үүссэн сурагчдын хөдөлгөөнийг дэмжихийн төлөө энэ сэтгүүлийг гаргажээ. Хэвлэгдсэн хугацаа тодорхойгүй².

Тус сэтгүүлийн хоёрдугаар хугацааны хураангуй гарчиг ба гол агуулгын Япон орчуулгын материалыг Японы судлаач Еокуда Модуку авгай “Ниффонд бүхий монголчуудын хурлын байгууллагын сэтгүүл (язгууртан улс)-ийн тухай” гэдэг өгүүлэлдээ ашиглаж танилцуулснаас энэ сэтгүүл бидэнд “хоцорч үлдэж чадсангүй”³ гэж харамслыг хөнгөрүүлжээ.

“Язгууртан улс”-ын хоёрдугаар хугацааны сэтгүүлийн “Дэвтрийн тэргүүний үгс” болон “тус сэтгүүл хэвлэгдсэний хойнох нэг жил”-ийг гаргавал “Шүүмж өгүүлэл”, “Уран зохиол”, “Орчуулгын зохиол”, “Тусгай гаргалт”, “Элдэв төрөгдөл” гэх таван булантай. “Шүүмж, өгүүлэл”-д “Үндэстний хувьсгал, нийгмийн хувьсгал хийгээд Монголын хувьсгал”, “Эрх чөлөөгөө хэрхэн олох

тухай", "Эрх ашигт горилох ба өнөөдрийн монголчууд", "Самин үзлийн Монголд авсан бодлого", "Монголын асуудал" гэх шүүмж зохиолуудыг нийтэлжээ. "Уран зохиол" бүлэгт "Эх орондоо буцсаны дараах миний бие", "Асга хадан дээрх нэрс", "Язгуур орон", "Найз", "Монголын төлөө гунирхсан нь" гэх зохиолуудыг гаргажээ.

"Орчуулгын зохиол" бүлэгт "Орчин үеийн монголыг судлах нь", "Үндэсний үүсэл хийгээд хөгжил" гэх хоёр зохиол оруулж, "Шилжүүлэн найруулсан зүйл"-д "Гадаад Монголын сурган хүмүүжлийн байцаалт", "Гадаад Монголын аж ахуйн тухай" гэх Гадаад Монголын тухай хоёр нийтлэл байж, "Элдэв зүйл"-д "Мөхөс хүн ч угсаагаа аврах арга замыг өгүүлсүгэй", "Мэдэгдэх нь", "Хойнох үг", "Зохиолын дүрэм хэмжээ" зэргийг тохируулжээ⁴.

Сэтгүүлийн гол болох нийтлэлийн япон орчуулгыг ажиглавал Монголын нийгмийн байдалтай холбогдуулан ардчилал эрх чөлөө жич хувьсгалын ёсыг ухуулж, бусад орнууд (ялангуяа гадаад Монгол)-ын байдлыг танилцуулахын хамт өөрийн үндэстний ахуй байдлыг задлан эмзэгийг уудалж, улмаар монгол угсаагаа аврах, жич мандуулан хөгжүүлэх арга замыг эрэлхийлжээ.

2. "Манхын хонх". Тус сэтгүүл 1935 оны 4-р сарын 13-нд их 32 зүсмийн хуудсан дээр монголыг тосон дармалаар, хятадыг хорголжин бараар хятад, монгол хавсарган гаргажээ. Сэтгүүлийн хэвлэл эрхэлсэн хугацаа дугаар нь манай үед хадгалагдан үлдсэн болохоор уг сэтгүүл чухам хэдий дугаар гаргасан, хэдэн хувь дармалладаг

байсан тухай одоохны материалын хувьд тодорхойлж чадахгүй болжээ. Сэтгүүлийн анхны дугаарын монгол эх бичгийг Өлзий, Борчууд, Саран, Цогбадрах нар бичиж байжээ.

"Манхын хонх"-ын анхны дугаар дахь Өлзийн бичсэн "Дэвтрийн тэргүүний үгс"-т: "...Тийнхүү хэрэв бид нар ард угсаагаа өнө удаан дэлхий дахин дээр тогтнуулмой хэмээн бодвоос эрхи биш эрдэм сургаалаа бадруулж, олон

түмний ухаан мэдлийг нээгдүүлэн, утга соёлоо урагш дэвшүүлээд, олон улсын ард угсаатны ухаан мэдэл лугаа дэн сацах болбаас сая ертөнцийн дээр тогтон чадмой. Хэрэв бас ч одоох мэт аливааг мэдэхгүйгээр өдрийг өнгөрүүлбээс удалгүй орон нутаг нь өөр хүнд нийлэгдэж, угсаа аймаг ч бас

хүний боол шивэгчин болохын аюул дайсан хүрч ирэх буй за. Тийнхүү манай хурлын бүх нөхөд бүгдээр ... ард түмний эрдэм сургаалыг дэлгэрүүлэх ба утга соёл, ухаан мэдлийг урагш дэвшүүлэхүйд өчүүхэн төдий тус болох буюу хэмээн санаж, нэгэн дармал дэвтэр гаргах"⁵ болсноо тушааж, сэтгүүл эрхэлсэн зорилтоо тодорхойлжээ. Уг сэтгүүлийн анхны дугаарт "Дармал гаргах үг", "Дэвтрийн тэргүүний үгс", "Нэгэн хүслэнжсэн төсөл", "Салхи бороонд найгалзсан Монгол", "Ухамсарч сэрсэн нь", "Ниффонд бүхий монгол сурагчдын үүрэг", "Дотоод Монголын өөртөө засахын шалтгаан болон өөртөө засах засгийн байдал", "Дотоод Монгол", "Эдүгээх манай Дотоод Монголд сургаал хүмүүжлийг түргэвчлэх чухал", "Гадаад Монгол", "Олон улсын байдлыг тоогоор харуулах

«

Харь гүрэнд суралцаж байгаа монгол залуус үндэстэн угсаатны мандал буурал, эрх ашиг, соёл гэгээрлийн төлөөнөө бодлого широн санааширч, улмаар "Ниффонд бүхий монголчуудын хурал" болон эвлэлдэж, "Язгууртан улс", "Манхын хонх", "Шинэ монгол" хэмээх сэтгүүлийг эрхлэн гаргажээ.

»

нь" гэх өгүүлэл шүүмжээс гадна "Дайн хийгээд хайр, хорсол", "Өргөл", "Олон нийтэд инээмсэглэсэн нь", "Амьдрал гэгч ийм сонихон", "Тэсрүүлсэн лам", "Хувилай", "Мөнх", "Ниффон улсад буудаллан байх монгол нутаг нөхдийн хурлын дуулал" зэрэг уран зохиолын нийтлэлүүд буй. Сэтгүүлийн анхны дугаар дахь нийтлэлийг ажиглавал Монголын нийгмийн асуудалд чиглэгдэж, монгол угсаатны доройтон буурсан шалтгааныг улс төр, аж ахуй, соёл сурган хүмүүжил, жич шашны талаас эрж үндэстнээ аварч хөгжүүлэх гэвэл соёл сурган хүмүүжлийг хөгжүүлж, ардын мэдлийг нээн, үндэстний соёлыг дээшлүүлэхэд буй гэж үзсэн мөртөө Монгол орны гэгээн саруул алсын "ирээдүй"-г нийгэм, аж ахуй, соёлын талаас төсөвлөн зурагласан байна.

3. "Шинэ монгол". Тус сэтгүүл 1941 оны 9-р сард монгол хорголжин бараар хэвлэгдэж эхэлжээ. Анхны дугаарын хавтсан дээр "Хөгжилдөх залуус" гэсэн зургийн баруун дээр талд Дэмчигдонровын "Шинэ монгол" гэсэн бичээсийг байрлуулж, зүүн дээд талд нь сэтгүүлийн дугаар ба доор талд "Ниффонд сууж бүхий монголчуудын хурал" гэж дармаллажээ. "Шинэ монгол" сэтгүүл 1941-1944 оны хооронд нийт 4 дугаар гаргаад цаг төрийн үймээн болон Японы ялагдлаас болж зогсчээ. Сэтгүүлийн зардлыг эл этгээдийн дэмжлэгт түшиглэн шийдвэрлэж "Монголын хязгаарын засаг" болон Манж улсын холбогдол бүхий байгууламжаас дэмжиж байсныг сэтгүүлийн талаарх мэдэгдлээс олж харах болно⁶. Тус сэтгүүлийн 1-3 дугаар хугацаа нь Японы Токиод, 4 дүгээр хугацаа нь Чуулалт хаалганд хэвлэгдсэн юм⁷.

Дармал эрхэлсэн зорилтын тухай тус сэтгүүлийн анхны дугаарт хурлын дарга Өлзий: "...Эдүгээ Ниффон улсад байх монголчуудын хурлаас ... урьд урагш гэгээрсэн Ниффон улсын утга соёлыг уул монгол нутагтаа танилцуулмой хэмээн нэгэн зүйлийн "Шинэ монгол" хэмээх дармал дэвтэр гаргаж,

аливаа утга соёл ба эрдэм сургаалын тухай зүйл бүхнийг зохион оруулж дармал гаргаад уул нутагтаа илгээж олон түмний ухаан мэдлийг сайжруулахад тус тэтгэм болгомой хэмээжээ" гэжээ. Мөн тус дугаарт хурлын дэд дарга Гаафунга "Дармал гаргах үг"-дээ "...Монголын өнийн байдлыг үзвээс шинэ эрдэм соёлыг удирдан оруулах ба хөгжүүлж дэлгэрүүлэх нь туйлын чухал учир мөн амой. Эдүгээ Ниффонд сууж бүхий монгол сурагч нар дахин шинэтгэн дармал гаргаж, Ниффоны шинэ соёлыг Монголд удирдан оруулж, Монголын эрдэм соёлыг хөгжүүлэн дэлгэрүүлэхэд тус болгосугай хэмээж бүхий нь Монголын нүдний өмнийн эргэлзэлт туйл нийлэлцэж, эрдэм соёлыг дэлгэрүүлэх дөхөм арга, дөт зам" гэж тодорхойлжээ⁸.

Сэтгүүлд "Шүүмжлэл өгүүлэл", "Судар шастир", "Газар зүй", "Ерийн мэдэл", "Хүүхдийн уншлага" гэх байнгын булантай. Гуравдугаар хугацаанд "Шүүмжлэл өгүүлэл" булангүй, энэ төрлийн зохиолыг "Сургаал соёл" гэх бүлэгт тохируулж, "Ятгал" гэсэн булан гаргаж уран зохиол нийтэлсэн бөгөөд "Зэргэлдээгийн чимээ" гэсэн булан гаргаж "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын эдүгээх байдал" гэсэн зохиол нийтэлжээ. Дөрөвдүгээр хугацаанд "Уянга зохиол", "Тусгай гаргалт" гэсэн хоёр тусгай бүлэг нэмж, гуравдугаар хугацаан дахь "Зэргэлдээгийн чимээ"-нд нийтэлсэн "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын эдүгээх байдал"-ын үргэлжлэлийг "Тусгай гаргалт"-д байрлуулжээ.

Сэтгүүлчийн нийтлэлүүдийг ажиглавал яг "Дармал гаргах үг"-д хэлсэн "Ниффоны шинэ соёлыг Монголд удирдан оруулж, Монголын эрдэм соёлыг хөгжүүлж дэлгэрүүлэхэд тус болгосугай" хэмээсэнчлэн нэгд: Японд олж үзсэн түүхэн ном материалаас эшлэж, Монголын дэлхий дахиныг дайлан дагуулсан түүх, жич умард Юань улсын товч түүхийг танилцуулахаар дамжуулж монголчуудын үндэстний

судлаач Л.А.Кохановагийн оновчтой тэмдэглэснээр: «Сэтгүүлч мэдээлэл цуглуулахаар гараад хөдөө аж ахуйн салбарын ажилтантай ч, усны салбарын төлөөлөгчтэй ч өөрсдийнх нь ярьдаг тус тусын хэлээр харилцаж чадахгүй бол түүний буруу. Гэхдээ хэрэв сэтгүүлчийн бичсэн нийтлэл сонины хуудаснаа хэвлэгдээд гараад ирвэл энэ нь ганц түүний төдийгүй, тухайн дугаарыг бэлтгэсэн хамт олны хариуцлага мөн. Тиймээс нэр томъёо, гарчигт гарсан болон ... бусад алдаа мэдгийн хариуцлагыг тухайн хэвлэлийн сэтгүүлчдийн бүхий л хамт олон адилхан үүрэх ёстой»². Дээрх гарчгийн үйл үгийн хэвийг анхаарах хэрэгтэй. Амиа хорлох гэдэг нь өөрөө үлдэх хэв. Тэгвэл загас өөрөө өөрийгөө өгүүтгэсэн хэрэг үү? Аль эсвэл хүний буруутай үйл ажиллагаанаас болж, тодруулбал гадны нөлөөгөөр өөрийн жам ёсны орчиндоо үхсэн үү?

Энэ бүхнийг сэтгүүлч толгойдоо тунгаасны дараа цаасан дээр буулгах ёстой.

Идэвхгүй хандлага

Экологийн сэдвээрх ихэнх материал ямар нэг зүйлийн, тухайлбал: албан ёсны мэдэгдэл, эсвэл холбогдох байгууллагын тайлангийн дагавар болж нийтлэгддэг. Энэ бол идэвхгүй сэтгүүл зүй, идэвхгүй хандлагын тод жишээ юм. Яагаад гэвэл энэ нь ОНМХ-ээр юу тусгахыг хэн нэгэн хэлж, зааж өгч байна, сэтгүүлчдийг удирдаж, чиглүүлж байна гэсэн үг юм. Экологийн сэтгүүл зүй эрэн сурвалжлах сэтгүүл зүйтэй ойр байдгийн хувьд сэтгүүлч хэзээ, яаж, юу бичихээ өөрөө мэддэг байвал зохино.

Сэтгүүлчийн өөр нэг дутагдал нь нэг нийтлэл биччихсэн л бол тэр сэдвийг өөрийнхөө хувьд хаадаг. Гэтэл экологийн аль ч асуудал нэгийн зэрэг нийтлэл, ярилцлагаар нааштай шийдэгдчихдэггүй. Тиймээс сэтгүүлч байн байн өнөөх сэдэвтээ эргэж очиж, урьд өмнө бичсэнээсээ шинэ зүйлийг

эрэлхийлэн, өөрөө идэвх гаргах хэрэгтэй.

Идэвхгүй хандлагын өөр нэг илрэл нь тодорхой нэг үйл явдалтай тохиолдуулж сэдвийг сөхөх явдал юм. Тухайлбал, Дэлхийн ган, цөлжилттэй тэмцэх өдрийг тохиолдуулан тогтмол хэвлэл, веб сайтад мэдээлэл гараад нэг хэсэгтээ намждаг практик тогтчи-хоод байна.

Цөлжилтийн асуудлыг тусгахдаа гадаадын жишээ баримтаар булдаг, энэ нь Монголд төдийлөн холбогдолгүй мэт сэтгэгдэл төрүүлэхээр бичдэг дутагдал мэр сэр боловч үзэгдсээр байна. Тухайлбал: «Цөлжилтийн өнөөгийн хурдаар бол 2025 онд дэлхийн хуурай газрын гуравны нэг нь цөлжиж, 2.3 тэрбум хvн цэвэр усны хомсдолд орохыг энэ салбарын эрдэмтэд тооцоолжээ. Энэ нь бидний монголчуудад ч хамаатай. Цөлжилт гэж юу байдгийн жишээ Сахарын цөлийг хvн бvхэн мэднэ»³.

Дараагийн жишээ ОНМХ-тэй холбогдолгүй ч цөлжилт Монголд хамааралгүй мэт бичдэгийн нэг тод илрэл болох юм. Хамгийн өргөн мэдээлэлтэй цахим «Википедиа» нэвтэрхий толины монгол хувилбарын «Цөлжилт» өгүүллийг үзэхэд ганц гэрэл зураг байгаа нь «Намиби улс дахь Намибийн цөл» гэсэн тайлбартай. «Говь» хэмээх үг 2 удаа, «Монгол» хэмээх үг 1 удаа тохиолдож буй юм («Австрали болон Говьд явагдаж буй»; «Монгол улсын нутгийн өмнөд хэсэгт орших Говьд цөлжилт эрчимтэй явагдаж, цөлийн бүс нь хүрээгээ хойш тэлсээр буй».)

Эдгээрийн зэрэгцээ өөр нэг түгээмэл дутагдал бол экологийн асуудлын тухай өгүүлчихээд хаа нэгнээс (тухайлбал: Засгийн газар, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хөдөлгөөн г. м.) авч буй арга хэмжээнүүдийг үгүйсгэх явдал юм. Тухайлбал: «Монгол Улс Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Ойн тухай үндэсний хөтөлбөр, Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр, Усны үндэсний хөтөлбөр,

Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр зэрэг 20 гаруй хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ажиллаж байна. Гэвч үр дүн нь төдийлэн харагдахгүй байгаа нь харамсалтай»⁴.

«Бид хаа нэгтээ хурал зөвлөлгөөн хийж л цөлжилтөөс «хамгаалж» байна. Улаанбаатар, Нью-Йоркт хичнээн том хуралд суугаад байхад өнөө элсний нүүдэл зогсдоггүй нь гачлан-тай» (Чив чимээгүй аюул, «Ардын эрх», 1997.06.17).

Цөлжилт бол экологийн хамгийн ноцтой гамшгийн тоонд ордог. Учир нь 1 см үржил шим бүхий хөрсийг нөхөн сэргээхэд 70-150 жил шаардлагатай байдаг. Гэтэл бид тэр даруй үр дүн гарахыг тэсэн ядан хүлээж, ингэхгүй бол элдвээр шүүмжилдэг. Энд нэг жишээ дурдмаар байна. 1970-

аад оноос БНХАУ-д Ногоон хэрэм босгож эхэлсэн. Энэ ажлыг 2050 он хүртэл үргэлжлүүлэхээр төлөвлөжээ. Энэ нь 13 мужийн нутгаар дамжсан, 4500 км урттай, 100 километрийн өргөнтэй мод, бут, сөөг, ургамлаас бүрдсэн хамгаалалтын бүс юм. Үүний үр дүнд 350 мянган км² газар нутгийг (Германы нутаг дэвсгэр) ногооруулах ажээ. Одоогийн байдлаар таригдсан мод жилд 200 сая тонн элсийг тогтоож байгаа гэсэн судалгаа бий. Энэхүү нүсэр төсөлд Хятадын ард түмэн тэр аяараа оролцож байна. 11-ээс 60 настай иргэн бүр жилийн дотор гурваас таван мод тарих, эсвэл зохих татвар төлөх үүрэгтэй⁵.

Гэтэл Засгийн газрын 2005 оны 5-р сарын 4-ний өдрийн хуралдаанаар «Ногоон хэрэм» Үндэсний хөтөлбөрийн батлагдсаныг тухайн үед шүүмжилж

байсан хэвлэл цөөнгүй. Нэг сэтгүүлч Байгаль орчны сайд У.Барсболдтой хийсэн «Биднээс хамаарах, хамаарахгүй хоёулангаас нь шалтгаалж цөлжилт үүсч байна» («Өдрийн сонин», 2005.10.18) гарчигтай ярилцлагаа бүхэлд нь улстөржүүлж, БОЯ-ыг үндэслэлгүй буруушааж шүүмжилсэн байдаг. Энд тэрхүү ярилцлагын ганцхан асуулыг л дурдъя: «"Ногоон хэрэм"-ийн үр дүн аль вэ? Яармагийн замаар явдаг олон хүн хэдэн хатсан бургасыг зааж танай яамыг тавалцгаадаг?» «Ногоон хэрэм» гэдгийг сэтгүүлч Яармагийн зам дагуу тарьсан бургас гэж ойлгосон бололтой.

Тэгвэл өнөөдөр энэ хөтөлбөрийн ачаар ямартаа ч 2500 га газар модтой болоод байна.

«

Экологийн сэдвээрх ихэнх материал ямар нэг зүйлийн, тухайлбал: албан ёсны мэдэгдэл, эсвэл холбогдох байгууллагын тайлангийн дагавар болж нийтлэгддэг. Энэ бол идэвхгүй сэтгүүл зүй, идэвхгүй хандлагын тод жишээ юм. Яагаад гэвэл энэ нь ОНМХ-ээр юу тусгахыг хэн нэгэн хэлж, зааж өгч байна, сэтгүүлчдийг удирдаж, чиглүүлж байна гэсэн үг.

»

Шалтгааныг зөв дурдах

Цөлжилт маш олон шалтгааны үр дүнд үүсдэг үйл явц юм. Тэдгээрийг ерөнхийд нь хүний үйл ажиллагаатай холбоотой болон байгалийн хүчин зүйл хэмээн ангилдаг. Үүнээс хүний нөлөөлөл нь 87 хувь, байгалийн нөлөөлөл 13 хувь байдаг. Цөлжилтөд хүргэдэг хүчин зүйлүүдийг тодорхой дурдсан, жишээ баримтаар харуулсан нийтлэл цөөнгүй бий. Гэтэл үүний сацуу этгээд, гаж зүйл ч бичиж байна: «Яндаж болдоггүй далай шиг... Эх нутгаа бид ийнхүү магтан дуулна. Дуулаад л... Холхи газраас цуурайтан "дуулдах" "...изм"-ыг баримжаалан шуурхайлж явтал ар хормой доогуур нэгэн муу ёр нүүрлэх шинжтэй болов. Энэ бол цөлжилт. Даян дэлхийг сэрдхийлгэж байгаа энэхүү газрын "СПИД", тэрхүү их аюул Монголд нүүрлэх бүрэн магадлалтай

бичиж үлдээснийг Фа Сиан анхааралтай уншсан болох нь мэдэгдэж байна. Тэрхүү тэмдэглэл чухам хэдий үед бичигдсэн нь тодорхойгүй боловч, ямар ч байсан V зуунаас өмнө болох нь эргэлзээгүй. Магадгүй Фа Сиан жуулчны аяллаас хоёр, гурван зуун жилийн өмнө ч бичигдсэн байж болно. Тэгэж үзвэл хятадууд одоогоос 2000 жилийн өмнө ч аяны тэмдэглэл бичиж байсан байхыг үгүйсгэх газаргүй байна. Харин бидэнд уламжилж ирсэн нь Фа Сианы тэмдэглэл юм.

Бидний сонирхлыг хамгийн их татаж байгаа зүйл бол Фа Сианы тэмдэглэл, ерөөсөө Хятадын жуулчдын тэмдэглэл монгол зам явахын бичигт нөлөөлсөн үү, нөлөөлсөн бол ямар арга замаар, яаж нөлөөлсөн бэ? гэдэг асуултын хариуг олох явдал мөн. Ингэхийн тулд хоёр зүйлийг тодруулах хэрэгтэй. Тэр нь Фа Сианы тэмдэглэл эртний монгол мэргэдийн дунд өргөн дэлгэр түгэж байгаад аажимдаа мартагдаж үгүй болсон уу, эсвэл тэр бичиг XIX зууны тэргүүн хагас хүртэл хэнд ч мэдэгдэхгүй дарагдаж байгаад гарч ирсэн үү? гэдгийг тодлох хоёр зүйлийн зорилт болно.

Юуны өмнө эдүгээ бидэнд уламжилсан Фа Сианы тэмдэглийг XIX зууны эхний хагаст Буриадын эрдэмтэн Банзарын Дорж франц хэлнээс орчуулсан байна. Эрдэмтэн Банзарын Дорж Буриадын нутагт төржээ. Дорно дахиныг судлагч нэрт эрдэмтэн Савельев «Хуандийн эртний судлалын нийгэмлэгийн Дорно дахины салааны бүтээл» гэдэг номдоо түүний намтар зохиолын тухай бичихдээ «Монголчуудын дотроос хамгийн их номтой хүн бөгөөд Европ, Дорно дахины гайхамшигт судлалтан мөн» гэжээ. Банзарын Доржийн тэрхүү орчуулгын уг эхийг наанадаж хоёр хувь үйлдсэн бөгөөд нэг нь Казань (Тогоо) хотын номын санд, нөгөөх нь Банзарын Доржийн багш, Польшийн нэрт эрдэмтэн Ковалевскийн хувийн номын санд хадглагдаж байжээ. Гэтэл Казань, Варшав

хоёр хот удаа дараа гал түймэрт автах үед тэр хоёр бичиг шатаж устсан гэж үзэх болсон байна. Энэ нь Банзарын Доржийн намтар зохиолыг эмхтгэн хэвлүүлэгчид уг бичгийг хайж олоогүйгээс үүдэн гарсан таамаглал байжээ.

Гэтэл тэр бичгийг уншиж судалсан, тэр ч байтугай хадгалж байсан хүн гарч иржээ. Тэр хүнийг цөхрөлтгүй эрж олсон хүн бол дооромбо Гэлэгжамц буюу номын нэр нь Буяндалай гэгч эрдэмтэй лам байв. Буяндалай Банзарын Доржийн багш Нэхийтийн Галсан гэдэг эрдэмтэй ламын садан төрлийн хүнд Фа Сианы тэмдэглэлийн нэг хувь бий гэдэг сураг гаргаад, цааш лавшруулан сурвалжилсаар Доржтой нэг нутгийн зайсан Цэвэгжавын Сампил гэгчийн үр удмынхнаас уг бичгийг олж авсан байна. Түүнээс нь нэрт бичгийн хүн Зава Дамдин нэг хувь хуулан авч, улмаар Монголын соёлын хүрээнд номын хэл (Classical language) гэгдэж байсан хоёр хэлний нэг болох төвд хэлнээ буулгасан аж.

«Буяндалайн олж авсан буриад бичээчийн үсэгтэй, орос цаасан дээр бичсэн нэгэн дэвтэр Судар бичгийн хүрээлэнгийн харьяа Улсын номын санд миний мэдэхээр 1927-1937 он хүртэл байсан» гэж академич Б.Ринчен тэмдэглэсэн байдаг. Түүний зэрэгцээгээр Зава Дамдин өөрөө хэрэглэх гэж хуулуулсан дэвтрээ Судар бичгийн хүрээлэнд хадгалуулахаар Жамъян гуайд өгснийг нь Гарсай гэдэг хүн 1924 онд Улсын номын сангийн ховор ном зохиолын дансыг үйлдэхдээ бүртгэж, хавтаслан, доторх нэрийг гадна талд нь сийрүүлэн бичжээ. Тэр монгол орчуулгын эх, төвд хуулбар хоёрыг 1977 онд Б.Ринчен гэрэл зургийн аргаар хадмаллан буулгаж, судалгааны өмнөх үгтэйгээр хэвлүүлсэн нь одоогийн бидний барьж байгаа Фа Сианы тэмдэглэл юм. Б.Ринчен уг тэмдэглэлийг хэвлүүлэхдээ тодорхойгүй цаг үед нангиадаас англиар орчуулсан нэгэн дэвтэр Энэтхэгийн Дели хотын номын дэлгүүрт байсныг 1957 онд олж авсан-

тайгаа тулгаж зарим нэг үгийн алдаа мэдгийг арилгасан байна.

Сүүлийн үед «Бурханы ном дэлгэрсэн улсуудад жуулчилсан бичиг» хэмээх эртний нийтлэлийн энэхүү дурсгалыг сонирхон судлах явдал олшрох хандлагатай болжээ. Манай сэтгүүл зүй судлаачдын анхааралд өртөөгүй байсан тэр бичгийг шинжлэх ухааны доктор Л.Норовсүрэн нийтлэл, сэтгүүл зүйн дурсгал болох талаас нь анхлан судалж «Монголын нийтлэл»² гэдэг гурван боть зохиолдоо дэлгэрэнгүй шинжилжээ. Мөн түүний удирдлагаар Монгол Улсын Их Сургуулийн оюутан Ч.Халиун уг тэмдэглэлийг кирилл бичигт буулгаж, оюутны эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьсан байна.

Гэвч дээр дурдсан баримтууд бол монголчууд Фа Сианы тэмдэглэлийг барьж үзэж, судалж шинжилсэн анхны тохиолдол хараахан биш гэж үзэж байна. Зарим судлаачийн үздэг шиг энэ тэмдэглэл хэдэн зуун жил дарагдаж байгаад гарч ирсэн биш, эртний Дорно дахинд түгэн дэлгэрч ихэд алдаршсан, улмаар Европ тивд ч түүнийг сайн мэддэг байсан бололтой. Үүний нэг баримт нь өнөөдөр бидний барьж байгаа тэр бичгийг аль тэртээх XIX зууны эхээр Францаар, бас тодорхойгүй үед англи хэлээр орчуулсан явдал мөн. Монголын эртний номч мэргэд Фа Сианы тэмдэглэлийг сайн мэддэг байсан төдийгүй түүний хэлбэр загварыг дуурайж зам явахын бичгээ туурвидаг байсан гэж үзүүштэй байна. Тэр нь дараа дараачийн зохиогчдын бүтээлд өвлөгдсөөр монгол зам явахын бичгийн тиг болж тогтсон гэж үзэх үндэс ч бий. Англи, франц, монгол, төвд хэлээр олон оронд хэвлэгдэж, XIX зууны сүүлч гэхэд монгол, буриадын нутгаас хэд хэдэн хуулбар нь олдсон энэ дурсгал бидний дээр дурдсанаас гадна, тухайлбал Монголын бичиг номтой хууччуулын сан хөмрөгт хадгалагдааар ирсэн байж болох, хойшид ч энд тэндээс гарч ирж болзошгүй бүтээл гэж үзэж байна.

«Бурханы ном дэлгэрсэн улсуудад жуулчилсан бичиг»-ийн одоо бидэнд мэдэгдэж байгаа хувилбар нь бийрийн бичгээс тэс ондоо бөгөөд тэр үеийн Ар Монголын худам бичигтэй лам нарын хулсан болон төмөр үзгээр бичдэг тигийг баримтлан финлянд цаасан дээр бэхээр бичсэн хуулбар юм. Хааяа ганц нэг хуудсыг ган үзгээр их дадамгай бичсэн нь Зава Дамдин гуайн бичгийн тигтэй таардаг байна. Мөн бичигт тэр үеийн тамгын газруудын болон лам бичээч нарын, түүнчилэн буриадын бичээч нарын байнга гаргадаг алдаа (зөв бичихэд баримталдаг дүрмийн ялгаа — Н.А.) мэр сэр үзэгдэж байгааг нэг мөр болгон залруулсан тухайгаа Б.Ринчен гуайн дурдсанаас үзвэл уг бичиг монгол газар бидний бодож байснаас илүү их тархаж, янз бүрийн төвшний бичээч нар гар дамжуулан хуулж авч байсан байхыг үгүйсгэх газаргүй мэт.

Европ ба Дорно дахинд аяны тэмдэглэл бичих хоёр өөр дэг сургууль тогтсон байдаг. Дорно дахины тэмдэглэл нэгд: үйл явдлын дарааллыг хатуу баримталсан байдаг, хоёрт: зам зуурт тохиолдсон үйл явдал, сонин хачин зүйлсийг нэгийг ч орхигдуулалгүй тоочин бичдэг онцлогтой байжээ. Гэтэл Европ дахины тэмдэглэл үйл явдлын дарааллыг төдий л их баримталдаггүй, үзсэн харсан зүйлээсээ онц сонирхолтойг нь сонгож бичдэг өвөрмөц аргатай юм.

XIII зууны үеэс хойш зохиогдсон монгол зам явахын бичгийн дурсгалууд өнөө үед мэр сэр уламжлагджээ. Тийм бүтээлийн тоонд 1228 оны үед бичигдсэн Елюй Чу Цайн «Баруун тийш аялсан тэмдэглэл», 1290 оны үед Европд зарагдсан монгол элч Бар Саум гэгчийн перс хэлээр бичсэн замын тэмдэглэл, 1777 онд Сүмбэ хамба Ишбалжирын бичсэн «Замбутивийг ерөнхийлөн номлогч үгс», XIX зууны үед буриадын бандид хамбо Агваандоржийн бичсэн «Дэлхийг эргэж бядсан домог сонирхлын бичиг», мөн

үед Чойжиданзанпэрэнлэйн бичсэн «Өмнөх замбутивийн байр байцыг дэлгэр номлосон тодорхой толь», XX зууны хориод онд И.Амгалангийн бичсэн «Цастын орныг зориод Цайдамын монголд саатсан нь» гэх мэт бүтээлийг нэрлэж болно.

Фа Сианы тэмдэглэл болон хятадын хэн нэг элч, жуулчны тийм ийм тэмдэглэлийг Монголын бичгийн мэргэд тэгэж ингэж судлаад үлгэр загварыг өөрийн бүтээлд ашигласан гэсэн бодитой баримтыг бид одоогоор олж үзээгүй байна. Гэвч хятад, монгол хоёр орон ном соёлын эртний гүн зузаан холбоотой байжээ. Тэр тусмаа нүүдэлчин монголчуудын түүх цадиг эртний хятад хэл дээр арвин байдаг, эзэн Чингис зэрэг

их хаад хүртэл төр улсын хэрэгт тохиолдсон чухал үйл явдлыг хятад бичгээр тэмдэглүүлдэг байсан зэрэг баримтуудыг дурдаж болно. Тийм байтал Монголын бичгийн мэргэд Фа Сианы тэмдэглэл хэмээх тэр алдартай бичгийг олж үзээгүй байна гэдэг санаанд багтамгүй хэрэг. Бидний бодлыг лавшруулж байгаа өөр нэг зүйл бол XIII зууны эхэн үеэс хойших 800 орчим жилд Монголын мэргэдийн бичсэн зам явахын бичгүүдийн өгүүлэх арга, бүтэц хэлбэр яг адилхан байгаа явдал мөн.

Жишиж үзье:

1. V зууны үед бичигдсэн Фа Сианы тэмдэглэлд: «Хияан ти улсаас өмнө зүгт дөрвөн хоног явбаас Боруша оронд ирмой. Эрт цагт бурхан шавь нар лугаа ийм хэмээн зарлиг болруун. Миний нярваан болсноос хойно энэ оронд нэг нэрт хаан төрж, энэ газар

суварга байгуулах больюу хэмээсэн ажгуу. Хойно нэг хаан ертөнцөд төрж замд мордоод тэр орноор явтал тэнгэрийн хаан хурмаст түүнээ санаа төрүүлэхийн тулд нэгэн залуу үхэрч хүмүүний дүрээр хувилаад зам дээр нь нэгэн суварга барьж байв. Хаан бээр түүнийг ихэд сайшаагаад, тэр малчны барьсан суваргаас өөр нэгэн суварга бариулсан ажгуу. Тэр суварга нь дөчин

ян-аас илүүгүй өндөр, элдэв эрдэнэсээр чимсэн тул хэн үзсэн бүхэн суварга ба сүмийн үзэсгэлэн ба жавхланг гайхмой. Тэр суваргыг нь замбутивийн хамаг суваргуудаас эрхэм хэмээн сонсогдсон бүлгээ. Хааны суварга бүтээсэн цагт их суваргаас өмнө бас гурван ян өндөр нэгэн бяцхан суварга бүтээмэй. Бурханы ба-

дар аяга тэр оронд буй».

2. 1228 онд Елюй Чу Цайн бичсэн «Баруун тийш аялсан тэмдэглэл»-д «Алтай уулын өмнө энгэрт уйгарын Бишбалаг хэмээх нэгэн хот байна. Тэнд Тан улсын үеийн хөшөө чулуу ч бий. Ханай жүн гэгч энэ болой. Хотоос баруун хойш хэдэн зуун газрын тойрог Ханай жүнд багтана. Нуурын дундах бага аралд жигүүртэн шувуудын өд ноолуур зөндөө. Хотоос баруун тийш 200 гаруй газрын зайтай Лүннай сианд мөн Тан улсын үеийн хөшөө чулуу бий. Хотоос өмнөнөш 500 газрын зайтай буй Хэззү бол Тан улсын үеийн Гоуцан мөн бөлгөө. Бас Инззү гэнэ. Гоуцангаас баруун тийш 3000-4000 газрын үзүүрт Удуан хот бий. Энэ нь даруй тан улсын үеийн Иүй тян улс юм. Энд хар, цагаан хас гардаг хоёр гол бий. Ханай жүнийг өнгөрч мянга гаруй газар явахлаар Бор хот байна. Гурваас таван дагуул

«

*Монголын эртний номч мэргэд,
төрийн элч төлөөлөгчид XIII зууны
эхэн үе гэхэд Ази, Европын олон
орноор явж үзсэн дуулсан сонин
хачин зүйлийнхээ тухай тэмдэглэн
үлдээдэг болсон байжээ. Тийм
бичгийг “Зам явахын бичиг” гэдэг
байв. Өнөөгийнхөөр бол “Аян замын
тэмдэглэл” юм.*

»

балгастай. Бор хотын өмнө Тэнгэр уул бий. Тэр нь зүүн, баруун тийшээ мянган газар, хойноос урагшаа 200 газар үргэлжилнэ».

3. 1225 оны үед Ли Чжичаны бичсэн «Чан Чун бумбын Өрнө зүгт зорчсон тэмдэглэл»-д «Дөрвөн зүгт алс тэртээд хот айл харагдах бөгөөд хар тэрэг, цагаан гэр байна. Ус, бэлчээр хайж хүн ард нь нэг газраас нөгөө газар нүүдэл хийнэ. Уулархаг газар ч, нам дор газар ч нэг ч мод үзэгдэхгүй бөгөөд тал бүрт уул шарлаж, ургамал гандуу харагдана. Хорь хоногийн турш явсаар зүүн хойд зүгт Хэрлэн гол руу цутгах нэгэн бяцхан голтой тааралдав. Голын ус морины хэвлийд хүрч байв. Голын эрэг хавиар уд сагсайж ургасан байв. Гол гатлан хойт зүгт явсаар нэгэн жижиг элсний тасархайд гарч ирэв. Дөрөвдүгээр сарын нэгэнд их тайж Отчигины ордонд хүрэлцэн ирэв. Тэр үед цас хайлж, нялх ногоо цухуйж байлаа».

4. XIX зууны сүүл үед М.Гомбожавын бичсэн «Их хятадын оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсний түүх хэмээх оршвой»-д «Зүүн этгээдээр Шанхай хэмээхүй далайд тулах бөгөөд өмнө бие талаар Ан нань, Тан тин тэргүүтэн хязгаарын хүмүүн лүгээ холилдсон. Зүг бусад хоёр Чан чэн буюу Цагаан хэрмээр чухамтай хүрээлсэн. Энэтхэг биеийн талаар уулаар хоёр түмэн ливар газраар хүрээлэн буй. Ер нутаг зүүн өмнөд бие рүү ихэд хэлбийгэр буй тул орны төвд Юэ диү бөгөөд орон их муж арван гурав хэмээхүй муж бага гурван сав, шим хоёулан арвидах, хомсдохуй ба дэлгэрэх, хурахын эрхээр хязгаар ямагт магад бус».

5. 1926 оны үед И.Амгалангийн бичсэн «Цастын орныг зориод Цайдамын монголд саатсан нь» гэдэг тэмдэглэлд: «Аялагч бид энэ мөчөөс цааш сэтгэл хатамжлан урагшилж, өдөр хоног өнгөрүүлэн явсаар Хан Тайшир уулын хошуунаа хүрэлцэн очиж, тэндээс цааш уурын тэрэг явж үл чадах тул Дээд Монголын нутаг хүртэл хэрэглэх

тэмээ хөсгийг орон нутгийн ардууд лугаа хэлэлцэн тохиролцов. Эндээс бид Баянзүрхийн хийдийн ойролцоох Цагаан толгой хэмээх худаг ус бүхий газар бүх зүйлээ чандлан цэгцлээд тэмээн жингээр хөдлөхөд хөндий тал мэлтийж, хүн амьтан үзэгдэх нь цөөрч, өөрийн улсын хилээс гарах ойртон, харийн газар хүрэх нь шахамдав. Согодын гол хэмээхэд хүрч, тэндээс ус авч тээвэрлэн цааш явтал уулын бэлд хоёр хөх майхан, нэгэн шовгор цагаан суварга мэт юм үзэгдэх ба нилээд тэмээ бэлчиж баймуй».

6. Өнгөрсөн зууны II хагаст Х.Гаадангийн бичсэн «Мартуу-зай хэмээн өгүүлсэн элдэв зүйл»-д «Би Япон оронд дөрвөн удаа очсон билээ. Цаг агаар, байгалийн байдал нь ер бусын гоёмсог. Бүх уул нуруу, тал газар өвс ногоогоор бүрхмэл. Уулнаас далай руу урсдаг гол мөрөн элбэг. Далайгаар хүрээлэгдсэн орон. Уулан дээр гарахад хатуу хөрстэй газар ховор. Чийг дааварласан хөрстэй, зарим газраа уулын орой нь намгийн байдалтай. Том хотуудын орчимд уулын модыг хот доторх цэцэрлэг шиг засаад гоё хээнцэр мод болгосон байх юм. Ирээдүйд байн байсаар нутгийнхаа бүх модыг засч магадгүй гэж бодогддог. Уулын хоорондох жаахан жалга зайнд хувийн жижиг сууц байшин дүүрэн. Манайхаар бол гэр хороолол юм. Ийм газрын жижиг хашаа, хүрээний дотор ба дов толгод маягийн газрыг ногооны газар болгож засаад цагаан будаа, хүнсний элдэв ногоо тарьдаг юм байна».

Дээр иш татсан хэсгүүдэд зам зуурт тааралдсан болгоныг их бага гэлгүй тэмдэглэдэг, байгаль, газар орны байдлыг зураглан үзүүлдэг, үзэгдэл үйл явдлыг эхнээс адаг хүртэл дэс дараалан харуулдаг, юмс, үйл явдал, газар орныг нарийн дүрсэлдэг, тоочлогын аргыг өргөн хэрэглэдэг зэрэг адил шинж түгээмэл байна. Товчоор хэлбэл өөр өөр цаг хугацааны үйл явдлыг нэг л хүн тэмдэглээд байгаа мэт сэтгэгдэл

төрүүлж байгааг ажиглаж болно. Энэ нь монгол зам явахын бичиг бүтэж бүрэлдэх тогтсон дэг сургуультай, тэр нь урт удаан хугацааны туршид хадгалагдсаар ирсэн, тэрхүү дэг сургуулийг эртний хятадын жуулчдын тэмдэглэлээс өвлөж авсан гэдэг дүгнэлт хийхэд хүргэж байгаа юм.

Монгол зам явахын бичиг орчин цагийн утга зохиол, тэр дундаа тогтмол хэвлэлийн нийтлэлд лавтай өвлөгджээ. Аян замын тэмдэглэл өнөөдөр сонин сэтгүүл, радио телевизийн практикт өргөн дэлгэрч байгаа үр өгөөжтэй, танин мэдэхүйн ач холбогдолтой нийтлэл нэвтрүүлгийн зүйл болж төлөвшсөн байна. Нийтлэлийн энэ зүйл хуучин уламжлал, шинэ арга барилын хослол болон хөгжиж байгааг тэмдэглүүштэй. Үүнийг хэд хэдэн зүйлээр тодорхойлж болно. Үүнд:

- Монголын эртний зам явахын бичгүүд аян замд гараад эргэж ирэх хүртэлх өдрийн тэмдэглэл, эсвэл үзэж харсан бүхний бичиглээс маягтай байсан бол, орчин үеийн аян замын тэмдэглэлд үзэж харсан бүхнээсээ сонголт хийж нийгэмд хэрэгтэй хэсгийг түүвэрлэн бичдэг болсон,

- Монгол зам явахын бичигт аяллын зам зуурт тохиолдсон зүйлийг дэс дарааллын дагуу, нэгбүрчлэн өгүүлдэг байсан бол, өнөөгийн аян замын тэмдэглэлд үйл явдлын дарааллыг төдий л харгалзахгүй болж, харин ч аль сонирхолтой хэсгээс нь эхэлж, өрнөл, туйл, тайлал, төгсгөл, уянгын гажилт зэрэг зохиомжийн аргуудыг өргөн хэрэглэх зэргээр илүү бүтээлч ханддаг болсон,

- Уламжлалт зам явахын бичигт үзэж харсан зүйл, үйл явдлыг зөвхөн тэмдэглэн үлдээдэг байсан бол, орчин цагийн тэмдэглэлд зохиогчийн дүгнэлт, эргэцүүлэл, үзэл бодлыг нэмж оруулдаг болсон,

- Эртний зам явахын бичиг хэмжээгээр том, бүхэл бүтэн ном болдог байсан бол, орчин цагийн тэмдэглэл

сонин, сэтгүүлийн тодорхой зай талбай, цаг хугацаанд баригдан хэмжээ нь жижгэрч, шуурхай чанар нь нэмэгдсэн,

- Хуучин цагийн зам явахын бичгүүдэд зохиогч үзэж харсан зүйлээ орхиж гээлгүй мэдээлэхийг эрхэмлэдэг байсан бол, өнөөгийн аян замын тэмдэглэл бичигчид танин мэдэхүйн шинжтэй мэдээлэл, тэргүүний дэвшилт зүйлийг илүүд үзэж, бичвэрийнхээ оюунлаг шинжид анхаарал тавих болсон,

- Эрт үед зөвхөн төрийн элч зараал хийгээд эрдэм номын хэргээр одогсод, аянчин жуулчингууд замын бичиг үйлддэг байсан бол, өнөө үед улс орны гадаад харилцаа нээлттэй болсноор бичлэгийн энэ зүйлийг зохиолч, сэтгүүлч төдийгүй утга зохиолын авьяас сонирхолтой аян ч бичих болсон зэрэг шинэчлэлүүдийг дурдаж болно.

Ишлэл

¹ Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн боть. УБ., 89 дэх тал.

² Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн боть. УБ., 87-89 дэх тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Амгалан И. 1991. Цастын орныг зориод Цайдамын Монголд саатсан нь. УБ.

2. Елюй Чу Цай. 1998. Баруун тийш аялсан тэмдэглэл. «Монголын уран зохиолын дээжис». XXXIII боть. УБ.

3. Ли Чжичан. 1997. Чан Чун бумбын Өрнө зүгт зорчсон тэмдэглэл. УБ.

4. 1999. Монголын соёлын түүх. Дэд боть. УБ.

5. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ.

6. Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн боть. УБ.

7. Поло М. 1987. Орчлонгийн элдэв сонин. УБ.

8. Фа Суан. 1970. Бурханы ном дэлгэрсэн улсуудад жуулчилсан бичиг. (Хуучин монгол, төвд бичгээр). УБ.

9. Кара Д. 1972. Книги монгольских ковчежников. УБ.

10. Мэн Хун. 1975. Полное описание монголо-татар. М.

11. Рашид-ад-дин. 1952. Сборник летописей. Т. 1. М.-Л.

Summary

This article recites travel diaries or journals as a genre of the Mongolian traditional publications. The travel diaries, one type of writing, were originated from Oriental litera-

ture and Mongolian linguistics started to write in this genre since the 13th century. The author highlights types and traditions of Mongolian travel diary, cited important factors which influenced the development of the genre as well as named the representatives of the genre. Furthermore, it has proved that Mongolians wrote travel diary much earlier than European writers.